

Санхүүгийн болон Удирдлагын нягтлан бодох бүртгэлийн хөгжилд мэргэжлийн тэнхимийн гүйцэтгэсэн үүрэг

The Department's Role in Financial and Managerial Accounting Development in Mongolia

Д. Нямаа¹, Н. Тунгалаг²

Хураангуй

1993 онд Нягтлан бодох бүртгэлийн тухай анхны хууль батлагдсанаар нягтлан бодох бүртгэл, аудитын харилцааны эрх зүйн орчин шинээр бий болж, өнөөгийн нягтлан бодох бүртгэлийн тогтолцооны суурь тавигдсан юм. Олон улсын жишигт нийцсэн нягтлан бодох бүртгэлийн мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэх шаардлагын дагуу өнөөдрийн түвшинд тус тэнхимээс санхүүгийн нягтлан бодох бүртгэлийг Санхүүгийн бүртгэл-1, Санхүүгийн бүртгэл-2, Санхүүгийн ахисан түвшний бүртгэл, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох бүртгэл, Салбаруудын нягтлан бодох бүртгэл, Нягтлан бодох бүртгэл-Англи хэлээр, Санхүүгийн тайлагнал, толилуулга; Зардал-удирдлагын бүртгэлийг Зардлын бүртгэл, Удирдлагын бүртгэл, Зардал-Удирдлагын бүртгэл, Бүтээгдэхүүний өртөг тооцолт, Ахисан түвшний удирдлагын бүртгэл зэрэг хичээлүүд болгон агуулгын хувьд гүнзгийрүүлэн, шинэчлэн сайжруулж хөгжүүлэн мэргэжлийн сургалтыг явуулж байгаа ба дээрх чиглэлүүд нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн судалгааны үндсэн сэдэв болж судалгааны ажлууд тогтмол хийгдэж байна.

Түлхүүр үгс: нягтлан бодох бүртгэл, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, мэргэжлийн судалгаа хөгжүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагын хөгжил

Abstract

The Accounting law in Mongolia was adopted in 1993 and it entered into force, which constitutes the appropriate legal framework to enforce implementation of international standards in accounting and auditing and was established a base of the current new accounting system. At present, the Accounting department responsible for teaching the following subjects in accounting, which are Financial accounting-1, Financial accounting-2, Advanced financial accounting, Cost Accounting, Managerial Accounting, Cost and Managerial Accounting, Costing, Advanced Managerial Accounting, International Financial Reporting Standards, Public Sector Accounting, Accounting for Industrial sector, Accounting in English and Financial reporting to prepare the professionals with accounting knowledge internationally recognized connecting to shipment of new accounting system and performing the accounting research in the above fields.

Keywords: financial and managerial accounting, curriculum innovation, professional research and development, development of accounting professional bodies

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн дэд профессор, доктор
E-mail: d.nyamaa@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн профессор, доктор
E-mail: tungalag88@yahoo.com

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл,
хэрэгжилт

*Зах зээлийн үеийн нягтлан бодох
бүртгэлийн хөгжлийн эхлэл үе буюу
1993-2001 он*

1993 онд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль батлагдсаны дараахан Дэлхийн банкны тусламжтайгаар АНУ-ын Лихайн Их сургуулийн профессор Джеймс Хоббс, Хенри Ховерстен нар манай оронд ирж хувьчлагдсан аж ахуйн нэгжийн санхүү, бүртгэлийн ажлыг хэрхэн хөтөлж явуулах талаар зөвлөгөө өгч, их дээд сургуулийн бүртгэлийн багш нарт 3 долоо хоногийн сургалт явуулж, энэхүү сургалтаар АНУ-ын нягтлан бодох бүртгэлийн “Нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим”-ыг заасан бөгөөд энэ нь зах зээлийн нягтлан бодох бүртгэлийн талаар хийгдсэн анхны системтэй сургалт байлаа (Дондог, 2009). Дээрх багш нарын лекцийг манай тэнхимийн багш Ч.Дашням, Б.Сайнжаргал нар эмхэтгэн “Зах зээлийн үеийн нягтлан бодох бүртгэл” номыг хэвлүүлсэн нь энэ чиглэлд гарсан анхны гарын авлага болсон.

Манай орны нягтлан бодох бүртгэлийг шинэчлэх, нягтлан бодогчдын мэргэжил, боловсролыг дээшлүүлэхэд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллага болон Австрали улсын засгийн газар ихээхэн үүрэг гүйцэтгэж 1993-1999 онд “Нягтлан бодох бүртгэлийг хөгжүүлэх”, “Нягтлан бодох бүртгэл, аудитын тогтолцоог сайжруулах нь” зэрэг удаа дараагийн төслүүдийг хэрэгжүүлж, төслийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн салбарын мэргэжилтнүүд, томоохон компанийн нягтлан бодогчид, их дээд сургуулийн мэргэжлийн багш нарт НББОУС-ын талаар сургалт явуулсан ба Филиппин улсын иргэн Макарио Севилла багш Санхүүгийн бүртгэл, Зардлын бүртгэл,

Бүртгэл мэдээллийн систем, Удирдлагад зөвлөгөө өгөх үйлчилгээ, Аудит, Аудитын дадлага гэсэн чиглэлүүдээр сургалтыг 1999 оныг дуустал удирдан явуулсан юм. Дээрх сургалтуудад манай багш нар хамрагдаж амжилттай төгсөн гэрчилгээ авсан ба АНУ болон Филиппин улсын мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтын хөтөлбөрт үндэслэсэн тусгай хөтөлбөрөөр сургалт явуулан 46 хүн хамруулж шалгалт авахад 18 хүн тэнцсэн байна. Тэнцсэн нягтлан бодогчдын дунд манай тэнхимийн багш Т.Жааваа, Н.Цэдвээ, Г.Мөнхзул, Ч.Батдолгор нар багтсан амжилт үзүүлж байсан.

1995 оноос их дээд сургуулиудын нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүд шинэчлэгдэх ажил манай сургуулиас эхэлж, бидний боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн сургалтын шаталсан хөтөлбөр (бакалавр, магистр, доктор)-ийг мэргэжлийн бусад их, дээд сургуулиуд загвар жишиг хөтөлбөр болгон ашиглах болсон юм.

Сургалтын агуулгын шинэчлэлийг хийж 2006, 2013 онуудад нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг үндэсний хэмжээнд хийлгэж, 2013 онд Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн магадлан итгэмжлэлийн олон улсын байгууллагад хөтөлбөрөө магадлуулж, нягтлан бодох бүртгэлийн бакалавр бэлтгэх стандартыг батлуулж мөрдсөн гэх зэргээр үндэснийхээ хэмжээнд нягтлан бодох бүртгэлийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх сургалтын бодлогыг тодорхойлж ирсэн юм (Мөнх-Очир, 2008).

Хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор юуны өмнө нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр ном, гарын авлага

бичиж боловсруулах, Англи хэлнээс орчуулах зэрэг ажлууд Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн чиглэлд анхлан хийгдэж энэ ажилд манай тэнхимийн багш нар идэвх чармайлт, сэтгэл зүтгэлтэйгээр оролцож ирсэн.

Санхүүгийн болон удирдлагын нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр тэнхимийн багш нарын бичиж боловсруулсан, редакторласан болон орчуулсан ном, сурах бичиг, гарын авлагыг тоймловол:

Хүснэгт 1. Санхүүгийн болон Удирдлагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын чиглэлээрх анхны бүтээлүүд

№	Ном, сурах бичиг, гарын авлага	Хэвлэсэн он	Эмхэтгэсэн, орчуулсан, бичиж боловсруулсан багш нар
1	Ж.Хоббс, Х.Ховерстен “Зах зээлийн үеийн нягтлан бодох бүртгэл”	1993	Эмхэтгэсэн Ч.Дашням Б.Сайнжаргал
2	Р.Мейгс, В.Мейгс. “Санхүүгийн бүртгэл” (орчуулга) Ред.: Л.Дондог, Ч.Дашням	1995	Тэнхимийн багш нар болон бусад
3	“Санхүүгийн бүртгэл” Ред.: С.Лүндэн	1995	Тэнхимийн багш нар
4	Мэррил Линч, Пиэрс, Финнер & Смийт Инк. “Санхүүгийн тайланг хэрхэн судлах вэ?” (орчуулга)	1996	Л.Дамбадорж
5	“Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-1996” (орчуулга) Ред.: Л.Дондог, Б.Сайнжаргал, Ч.Дашням	1997	Л.Дамбадорж, Д.Нямаа, Г.Нанжид, С.Лүндэн, Ч.Дашсамбуу, Ч.Батдолгор, С.Жавзандолгор, Т.Жааваа, Р.Бадамханд, Н.Тунгалаг, Н.Цэдвээ нар болон бусад
6	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын тайлбар	1998	Д.Нямаа болон бусад багш нар
7	Санхүүгийн бүртгэлийн гарын авлага	1999	Б.Сайнжаргал, Т.Жааваа, Н.Цэдвээ
8	“Ахисан шатны нягтлан бодох бүртгэл” гарын авлага	2000	Д.Нямаа
9	Зардлын бүртгэл: Бодлого, дасгал, сорил	2000	Н.Тунгалаг
10	Асри Хаммер “Зардлын нягтлан бодох бүртгэл” сурах бичиг (орчуулга)	2000	Н.Тунгалаг, Д.Нямаа болон бусад багш нар

Эх сурвалж: Судлаачийн тоймлосноор

Зах зээлийн үеийн нягтлан бодох бүртгэлийн хөгжлийн өрнөлийн үе буюу 2001-2018 он

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хэрэгжилтийн энэ үе шатанд санхүүгийн бүртгэлийн чиглэлээр Д.Е.Кейсо “Дунд шатны нягтлан бодох бүртгэл”, Асри Хаммер “Зардлын нягтлан бодох бүртгэл” сурах бичгүүдийг их дээд сургуулийн багш нар, мэргэжилтнүүдийн хүчээр Англи хэлнээс орчуулан олны хүртээл болгосноор эдгээр нь мэргэжлийн багш нарын төдийгүй нягтлан бодох бүртгэлийн

мэргэжилтнүүдийн мэргэжлийн мэдлэгийн тулгуур үндэс, ширээний ном (Батжаргал, 2011) болж цаашид санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн олон ном, сурах бичиг бичигдэх үндэс болж хэрэглэгдсээр ирсэн юм. Тэнхимийн багш нарын бичиж боловсруулсан санхүүгийн бүртгэл, тайлагнал, зардал, удирдлагын бүртгэлийн чиглэлээрх ном, сурах бичгүүд МУИС-д төдийгүй нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэдэг бусад их, дээд сургуулиуд, мэргэжлийн байгууллагуудын сургалтанд хэрэглэгдсээр байна.

Хүснэгт 2. Санхүүгийн болон Удирдлагын нягтлан бодох бүртгэл,
тайлагналын чиглэлийн ном, сурах бичгүүд

№	Ном, сурах бичиг, гарын авлага	Хэвлэсэн он	Эмхэтгэсэн, орчуулсан, бичиж боловсруулсан багш нар
1.	Ред. А.Өнөржаргал “Санхүүгийн дунд шатны нягтлан бодох бүртгэлийн тест, бодлогын хураамж”	2002	Тэнхимийн багш нар
2.	Ерөнхий редактор Л.Дондог “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-2003” орчуулга	2004	А.Еркеш, Д.Нямаа, Г.Нанжид, Т.Жааваа, Г.Алтанзаяа, Ч.Дашсамбуу, Н.Цэдвээ, Л.Мөнх-Очир, Л.Дамбадорж, А.Өнөржаргал
3.	“Зардал-Удирдлагын бүртгэл: шинжилгээ, загварчлал	2004	Н.Тунгалаг
4.	“Зардал-Удирдлагын нягтлан бодох бүртгэл”, I, II дэвтэр	2005	Ц.Баянмөнх
5.	“Санхүүгийн бүртгэл” гарын авлага	2006	А.Еркеш, Б.Нүржигмаа
6.	Ред. Л.Дамбадорж, А.Өнөржаргал, Р.Бадамханд “Санхүүгийн дунд шатны бүртгэл” сурах бичиг I, II боть	2009	Тэнхимийн багш нар
7.	“Санхүүгийн ахисан түвшний нягтлан бодох бүртгэл” сурах бичиг	2010	Д.Нямаа
8.	“Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн тунхаглалын гарын авлага-2011” орчуулга	2012	Н.Тунгалаг болон бусад
9.	Зардал-Удирдлагын бүртгэл (ахисан түвшин)	2012	Н.Тунгалаг
10.	“СТОУС-2013-ын хэрэглээний тайлбар”	2014	Д.Нямаа, Р.Бадамханд нар болон бусад
11.	“Санхүүгийн бүртгэл-1” хичээлийн тест, бодлогын хураамж	2014	А.Өнөржаргал, Д.Нямаа, А.Еркеш
12.	“Уул уурхайн салбарын нягтлан бодох бүртгэлийн онцлог”	2015	Р.Бадамханд
13.	“Санхүүгийн нэгтгэсэн тайлагналын онол, арга зүйн зарим асуудал”	2015	Д.Нямаа
14.	“Зардал-Удирдлагын нягтлан бодох бүртгэл”, I, II дэвтэр (2 дахь хэвлэлт)	2014	Ц.Баянмөнх
15.	“Нягтлан бодох бүртгэл” ном	2016	А.Еркеш, О.Нүржигмаа
16.	“Өртгийн бүртгэл”	2016	Г.Мөнхзул, Г.Алтанзаяа
17.	“Удирдлагын нягтлан бодох бүртгэл”	2010, 2015	Т.Жааваа
18.	“Зардлын нягтлан бодох бүртгэл”	2012, 2017	Н.Тунгалаг, Д.Авирмэд
19.	“Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хэрэглээ”	2017	Г.Алтанзаяа
20.	“Ахисан түвшний санхүүгийн нягтлан бодох бүртгэл” тест, бодлогын хураамж	2017	Д.Нямаа, Г.Мөнхтуяа
21.	“Student Workbook for Fundamental Accounting”	2018	Б.Алтан-Эрдэнэ, Л.Оюунцэцэг, Д.Баттуяа, Э.Ундармаа
22.	“Удирдлагын бүртгэл”, 3 дахь хэвлэлт	2018	Д.Моломжамц

Эх сурвалж: Судлаачийн тоймлосноор

Түүнчлэн, багш нараа олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын сургалтанд хамруулан тэднийг тасралтгүй хөгжүүлж ирсэн ба 2008 онд Дэлхийн банк, Англи Уэлсийн Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтээс хамтран зохион байгуулсан "СТОУС-ын сургагч багш"-ийн on-line зайн сургалтанд багш Д.Нямаа, А.Еркеш нар амжилттай оролцож зохих шалгалтуудад тэнцэн сертификат авсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн хөгжлийн энэ үе шатанд нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр тэнхимийн багш нарын туурвисан ном, сурах бичиг, гарын авлагыг Хүснэгт №2-т үзүүлэв.

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явц одоо ч үргэлжилсээр байгаа бөгөөд бид санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцоог олон улсын жишиг стандартад нийцүүлэхийн зэрэгцээ санхүүгийн мэдээллийн чанарыг сайжруулах асуудалд онцгойлон анхаарч, санхүүгийн тайлагналын стандартын шаардлага бүрт нийцсэн санхүүгийн тайлагналыг бий болгох чиглэлд хөтөлбөрөө улам бүр сайжруулан хөгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мэргэжлийн судалгаа хөгжүүлэлт

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн судалгааны нэг үндсэн чиглэл нь санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын асуудал юм. Бакалавр, магистр, докторын түвшний суралцагчид санхүүгийн тайлагналын асуудлаар судалгаа хийж олон оюутан бакалаврын болон магистрын судалгааны ажил бичиж хамгаалсны зэрэгцээ оюутны эрдэм шинжилгээний хуралд илтгэж тавьж хэлэлцүүлсээр ирсэн.

Багш нар сэдэвт ажил, бизнесийн байгууллагын захиалгат судалгаа

боловсруулалтын ажлын зэрэгцээ 1998-1999 онд "Монгол улсын бүртгэл, санхүү, банкны тогтолцоо", 2000-2002 онд "Бизнесийн болон ашгийн бус байгууллагын бүртгэл тайлагнал, аудитын тогтолцоо" сэдэвт төслийн ажлыг Сангийн яамны захиалгаар гүйцэтгэж, 2004-2005 онд "Санхүүгийн тайлан бэлтгэх үзэл баримтлалын зарчмууд" сэдэвт ахисан түвшний судалгааг хийсний зэрэгцээ 2017 онд Сангийн яамны захиалгаар хийгдсэн "СТОУС-ын нэвтрэлтийн байдал" төслийн судалгааны багт багш Д.Нямаа зөвлөхөөр оролцсон байна.

Тэнхимийн багш, судлаачдаас санхүүгийн тайлагналын асуудлаар анх 2003 онд багш Т.Жааваа "Үндэсний бүртгэлийн тогтолцоог шинэчлэх асуудал" сэдвээр диссертаци бичиж Шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан ба 2006 онд багш Ц.Гунгаанямбуу "Санхүүгийн тайлагналын үндэсний стандартын онол арга зүйн тулгамдсан асуудал" сэдвээр, 2008 онд С.Эрдэнэбилэг "Гадаадын зээл тусламжийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын тогтолцоог сайжруулах асуудал" сэдвээр, 2014 онд багш Д.Нямаа "Санхүүгийн нэгтгэсэн тайлагналын онол, арга зүйн зарим асуудал" сэдвээр, Б.Болормаа "Олон улсын стандартыг аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлд нэвтрүүлэх нь" сэдвээр тус тус докторын судалгааны ажил хийж диссертаци бичин доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан бол зардал удирдлагын бүртгэлийг хөгжүүлэх асуудлаар 1993 онд Т.Жааваа "Үйлдвэрлэлийн зардлын бүртгэл хяналтын тогтолцоог боловсронгуй болгох арга зам" сэдвээр, 1999 онд Н.Тунгалаг "Удирдлагын бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх зарим асуудал" сэдвээр докторын зэрэг хамгаалсан юм.

Дээрх багш судлаачдын бүтээлийг мэргэжлийн чиглэлээр судалгаа хийж байгаа оюутан суралцагчид болон нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүд эрдэм судлал, шинжилгээний ажилдаа эшлэн ашиглахын зэрэгцээ тэдний бүтээлээрээ боловсруулан гаргасан арга зүйн заавар, зөвлөмж, аргачлалыг санхүүгийн бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтандаа ашигласаар байна.

Мэргэжлийн байгууллалуудын хөгжил, төлөвшилд оруулсан хувь нэмэр

Манай улсад нягтлан бодох бүртгэлийн бодлогын үйл ажиллагааг 1993 он хүртэл Сангийн яам дангаараа зохицуулж ирсэн бөгөөд Сангийн сайдын 1993 оны 3-р сарын 26-ны өдрийн 69 тоот тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн орон тооны бус зөвлөл, 1996 оны 3-р сард болсон Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын анхдугаар зөвлөгөөнөөр Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт байгуулагдсан нь дэлхийн жишигт нийцсэн нягтлан бодох бүртгэлийн тогтолцоонд шинэ алхам болсон (Батжаргал, 2016) ба нягтлан бодох бүртгэл, аудитыг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэгтэй дээрх мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг төлөвшүүлэхэд манай тэнхимийн багш нарын гүйцэтгэсэн үүрэг их.

1993 онд батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд манай улсын бүртгэл, аудитын салбарын анхны мэргэжлийн байгууллагын суурь болох “Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөл” байгуулах тухай заалт орсны дагуу мэргэжлийн зөвлөлийг 22 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба тэднээс 3 гишүүн нь (Б.Сайнжаргал, Л.Дамбадорж, Г.Нанжид нар) манай тэнхимийн багш

нар төдийгүй уг байгууллага 1996 онд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт (ММНБИ) болсноос хойш өнөөдрийг хүртэл тус байгууллагын Удирдах зөвлөлд Б.Сайнжаргал багш тасралтгүй, Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд Д.Нямаа, НББ-ийн сургалтын болон арга зүйн төрөлжсөн хороод, Эрдмийн зөвлөлд Л.Наранчимэг, Д.Моломжамц, А.Еркеш нарын зэрэг олон багш ажиллаж ирлээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль батлагдсаны дараа олон улсын жишгийн дагуу мэргэшсэн нягтлан бодогч бэлтгэх шаардлага тулгарч анхны шалгалтыг нягтлан бодох бүртгэлийн онол, хуулийн мэдлэг, бүртгэлийн дадлага хичээлүүдээр авсан бөгөөд нягтлан бодох бүртгэлийн онол, дадлагын хичээлийн сорилго асуулт болон, цогц бодлогыг багш Б.Сайнжаргал, Л.Дамбадорж нар боловсруулан, шалгалтыг зохион байгуулж авснаар Монгол улсад анхлан 16 мэргэшсэн нягтлан бодогч төрөн гарсан байна.

1996 онд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр “Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт-1996”-г орчуулан хэвлэсэн ба стандартын энэхүү анхны орчуулгын ажилд манай тэнхимийн багш (Л.Дамбадорж, Д.Нямаа, Г.Нанжид, С.Лүндэн, Ч.Дашсамбуу, Ч.Батдолгор, С.Жавзандолгор, Т.Жааваа, Р.Бадамханд, Н.Тунгалаа, Н.Цэдвээ нар болон бусад) нар орчуулгын багийн гишүүнээр ажилласан юм. НББОУС Монгол хэлээр хэвлэгдэн гарснаар нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдийг зах зээлийн үеийн нягтлан бодох бүртгэлд сургах, санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн чиглэлээрх ном, гарын авлага, сурах бичиг бичиж сургалтанд ашиглах болон аж ахуйн нэгж, байгууллагад НББОУС-ыг нэвтрүүлэх гол

нөхцөл бүрдсэн гэж үзэж болно.

Бид ММНБИ-ийн анхны багш нар болж НББОУС-ын олон удаагийн сургалтанд хичээл зааж, нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо болон мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах олон удаагийн төсөл, хөтөлбөрүүдэд сургагч багш, төслийн зөвлөхөөр ажиллаж ирсэн юм.

Өнөөдөр манай тэнхимийн багш нарын 90 орчим хувь нь Монгол улсын хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчид бөгөөд мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд манлайлан оролцож, хөгжилд хөл нийлүүлэн мэргэжлийн хувьд тасралтгүй хөгжсөөр байна.

Дүгнэлт

Монгол улс зах зээлийн харилцааны шинэ тогтолцоонд шилжих шинэчлэлийн шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэл, хяналтын тогтолцоо, арга горим, дүрэм журам, мэргэжилтэн бэлтгэх, сургах системээ бүхэлд нь өөрчилсөн түүхэн хөгжлийн бүхий л үе шатанд МУИС-ийн нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн тэнхим анхдагч нь байж, нягтлан бодох бүртгэлийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, тэднийг тасралтгүй боловсруулан хөгжүүлэх сургалтын бодлогыг тодорхойлж, мэргэжлийн судалгаа хөгжүүлэлтийн чиглэлд эрдэм

судлалын төв нь болж хөгжиж ирлээ.

Нягтлан бодох бүртгэлийг бие даасан компани, жижиг дунд аж ахуйн нэгжийн түвшинд төдийгүй ахисан түвшин болох групп компани (толгой болон охин компаниудаас бүрдсэн)-д хэрхэн хөтөлж, санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж толилуулах, зардал, удирдлагын бүртгэл хөтөлөх асуудлыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын болон бизнесийн практик шаардлагад нийцүүлэн, үнэн зөв тайлагнал буюу санхүүгийн болон удирдлагын мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ уул уурхай, хөдөө аж ахуй, барилга, банк санхүү, даатгал зэрэг салбарын нягтлан бодох бүртгэлийн чиглэлд сургалтын хөтөлбөрийг улам бүр сайжруулан хөгжүүлж, хэрэгжилтийг хангахад анхаарч ирсэн.

Цаашид, санхүүгийн бүртгэл тайлагнал, СТОУС-ын үзэл баримтлал, зарчим, хэрэглээний асуудлаар болон Зардал-Удирдлагын бүртгэлийн судалгаа боловсруулалтыг эрчимжүүлэн, судалгаанд суурилсан сургалтыг улам бүр төлөвшүүлэн, ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн агуулга, хэлбэр, үр дүнг сайжруулах чиглэлд анхаарч ажиллах зорилтыг дэвшүүлэн хичээн ажиллаж байна.

Ашигласан материал

1. Батжаргал, Р. (2011). Монгол улсын зах зээлийн үеийн нягтлан бодох бүртгэл, аудитын хөгжлийн эхлэл ба өрнөл, *“Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн товч түүх”* ном, 69-86
2. Батжаргал, Р. (2016). Анхдагч байх том үүрэг, хариуцлага, *“Хамтдаа хөгжсөн 20 жил”* ном, 12-22
3. Болормаа, Б. (2011). Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хэрэглээ, тулгамдсан асуудал, *“Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартчлал”* ЭШХ-ын эмхэтгэл, 27-42
4. Дондог, Л. (2009). Зах зээлийн эдийн засагт шилжих үеийн нягтлан бодох бүртгэл, төрийн бодлого, *“Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт”* сэтгүүл, №2, 2-6
5. Мөнх-Очир, Л. (2008). НББ-ийн тэнхимийн үүсэл, хөгжил, өнөөгийн байдал, *“Нягтлан Бодох Бүртгэлийн Тэнхим”* ном, 5-16
6. Сайнжаргал, Б., Энх-Амгалан, Л. (2003). Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын агуулгыг боловсронгуй болгох асуудал, *“Ахмад ба залуу үеийн зарим нягтлан бодогчдын дурсамж, бодрол”* ном, 80-88